2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Техник импорт ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15.00 цагт Баянгол дүүрэг, 28-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн "Хурлын танхим"-д боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссоос Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг үндэслэн Техник импорт ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн №26/269 тоот албан бичгийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон ирүүлсэн Техник импорт ХК-ийн "Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй болон дэлгэрэнгүй судалгаа"-гаар бүртгэлийн ажиллагааг явуулахад Техник импорт ХК-ийн 1 446 755 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 468 хувьцаа эзэмшигчээс 973 194 ширхэг хувьцаа эзэмшдэг 3 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр, нийт 456 464 хувьцаа эзэмшдэг 14 хувьцаа эзэмшигч бүртгүүлэв.

Тооллогын комиссын бүртгэлийн ажиллагаа 15 цаг 20 минутанд дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга Д.Пүрэвсүрэн "Хурлын бүртгэлийн ажиллагаагаар тус хуралд 1 429 658 ширхэг хувьцаа эзэмшдэг 17 хувьцаа эзэмшигч оролцохоор бүртгүүлсэн нь компанийн 1 446 755 ширхэг энгийн хувьцааны 98,8 хувийг бүрдүүлж Компанийн тухай хуулийн 69.2, Техник импорт ХК-ийн "Дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.26-д заасныг тус тус хангасан тул 2026 оны Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай" ирцийн мэдээллийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргад илтгэв.

Хурлын бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа хурал зохион байгуулах комиссоос хурлын дэгийн талаарх танилцуулга, хэлэлцэх асуудалтай холбогдох материал, саналын хуудсуудыг Хувьцаа эзэмшигчдэд тарааж өгөв.

Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Д.Ганцэцэг даргалан удирдаж явуулав.

Хурлын дарга Тооллогын комиссын дүнг үндэслэн хурлыг нээх, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлуудыг батлах эсэх талаар хувьцаа эзэмшигчдээс санал хураахад хуралд оролцсон нийт 17 хувьцаа эзэмшигч санал нэгтэй "зөвшөөрснөөр" хурлын ажиллагаа эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Техник импорт ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Ж.Баярсайхан, Цалин, урамшууллын хорооны дарга, хараат бус гишүүн Б.Батсайхан, ТУЗ-ын гишүүн Г.Уран-Өлзий, ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам нар оролцов.

Хурлын эхэнд хүрлын дэг болон хурлын хэлэлцэх асуудлуудтай холбоотой статистик мэдээ, тайланг дараалын дагуу хурлын танхимын хананд байрлуулсан дэлгэцэн дээр байршуулж харуулсан байв.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. 2025 оны ногдол ашгийн талаарх ТУЗ-ын шийдвэрийг батлах
3. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан

4. 2026 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан
5. 2025 оны компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
6. 2026 оны ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүнийг сонгох

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, уг хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дарга, тооллогын комиссыг томилсон талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 тоот тогтоолыг Хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хурлын хэлэлцэх эхний асуудал "2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2025 оны ногдол ашгийн талаарх ТУЗ-аас гаргасан тогтоол"-ыг ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Ж.Баярсайхан уншиж танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хурлын дарга Д.Ганцэцэг компанийн 2025 оны компанийн үйл ажиллагааны тайлан, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар тус тус танилцуулав.

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам Техник импорт ХК-ийн 2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцсэн асуудлуудыг танилцуулж дууссаны дараа хурлын дарга Д.Ганцэцэг хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан асуудлаар асуух, тодруулах зүйл байгаа эсэх талаар асууж хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултын дагуу холбогдох тайлбар, мэдээллийг өгөв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Тайлант хугацаанд өр авлагыг яаж барагдуулж ажиллав?

Хурлын дарга Д.Ганцэцэг: 2025 онд компани банкны нийт зээлээс 13 гаран тэрбум төгрөгийн зээлийг барагдуулж ажилласан. Зээл, авлагыг барагдуулж ажилласанаар компанийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө гэж харж байгаа. Зээлийн хүү буурна, харьцангуй ачаалал багасна, Мөн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Хувьцаа эзэмшигч Г.Ганзориг: Компани дээр борлуулагдаж байгаа байрууд хаагуур байршилтай, ямар байрууд байдаг вэ?

Хурлын дарга Д.Ганцэцэг: Байршлын хувьд хотын бүх дүүргүүдэд байгаа. Хэмжээний хувьд янз бүр байгаа. Манай компани Худалдаа, хөгжлийн банктай хамтарч ажилладаг. Та бүхэн хэрвээ байр сонирхож байгаа бол манай компанийн байрны борлуулалтын албаныхантай уулзаарай. Тэндээс хэрэгтэй, хүссэн бүх мэдээллийг авч болно. Шаардлагатай бүх материал бүрдсэн тохиолдолд банкны ипотекийн зээлд хамруулж өгч болно. Бусад банкуудтай харьцуулж үзэхэд байр худалдан борлуулах чиглэлээр Худалдаа хөгжлийн банктай хамтран ажилладаг учраас ипотекийн зээлд цаг хугацааны хувьд хүндрэл багатай хамрагддаг гэдгийг хэлмээр байна. Өөр асуулт байна уу. Байхгүй бол хэлэлцэх асуудлаар санал хураалтыг явуулья.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй ээ. Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Сэтгэгдэл өндөр байна.

Хурлын дарга Д.Ганцэцэг: За тэгвэл хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцсэн асуудлын талаар хурлаас гарах тогтоолын төсөлд саналын хуудсаар санал хураалт явуулья. Тооллогын комисс саналын хуудсаар санал авч, дүнг нэгтгэн танилцуулна уу.

Хурлын танхимд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагаа явагдав.

Тооллогын комиссын дарга Д.Пүрэвсүрэн: Тооллогын комисст компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% буюу 1 429 658 ширхэг хувьцаа эзэмшигчийн саналын хуудас ирсэн. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар хэлэлцэх асуудалд саналаа өгсөн байна. Нийт тоологдсон саналын хуудас 17 байна. Үүнээс хүчинтэй саналын хуудас 17, хүчингүй саналын хуудас байхгүй байна. ТУЗ-ын гишүүдийг сонгох саналыг кумулятив аргаар дүгнэж гаргасан. Хурлаар хэлэлцсэн бусад асуудлыг нэг бүрчлэн “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” хэлбэрээр санал авч саналын хуудсуудын дүнг нэгтгэж гаргасан. Саналын хуудсуудыг нэгтгэн дүгнэж үзэхэд хуралд оролцогч нийт 17 хувьцаа эзэмшигч хурлаар хэлэлцсэн 6 асуудлыг бүгд 100%-ийн саналаар дэмжиж зөвшөөрсөн учир хурлын саналын хуудсуудыг үндэслэн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах Тооллогын комиссын тогтоолын төслүүдийг батлуулах шийдвэрийг гаргаж байна.

Хурлын дарга Д.Ганцэцэг: Тооллогын комиссоос хурлын хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авч саналын дүнг нэгтгэж гаргасныг танилцуулж дууслаа. Хурлын хэлэлцсэн асуудлууд 100 хувийн саналаар дэмжигдсэн байна. Тооллогын комиссын дүнг баталж тогтоолын төслүүдийг батлах уу?

2026 оны Хувьцаа эзэзмшигчдийн ээлжит хуралд оролцсон Техник импорт ХК-ийн нийт 17 хувьцаа эзэмшигч гараа өргөснөөр хурлаас гарах тогтоолын төслүүд батлагдав.

Хурлын дарга Д.Ганцэцэг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудыг Хувьцаа эзэмшигч та бүхэн зуун хувь зөвшөөрч дэмжсэн тул 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг батлах шийдвэрийг гаргаж байна. Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилтыг хүсье. Энэ удаагийн хуралд хувьцаа эзэмшигчид олноороо ирж оролцсон та бүхэнд талархлаа илэрхийлье. Ирэх жил хурлаа илүү том танхимд хийх хэрэгтэй юм байна. Хурал өндөрлөснийг мэдэгдэж байна.

Хурал 17 цаг 10 мин дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

ТУЗ-ын нарийн бичгийн дарга: О.Бүжинлхам

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА: Д.ГАНЦЭЦЭГ

Техник импорт ХК 2057239 УОМ 0064